*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА А.АМАРСАЙХАНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**
Нэгжийн нэр: **ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР**

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь) | (Биелэлтийн хувь * 70 / 100%) |
| | | 60.75 | 60.75 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтанд хамрагдах | 15 | 15 |
| 2. | Арга хэмжээ 2. | 15 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 15 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 15 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |

| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
|---|---|---|
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 15 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 15 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 15 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 15 |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 60.75 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 90.75 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
*(албан тушаал)*

*(гарын үсэг)*

/ А.ЭНХМАНЛАЙ/
*(албан хаагчийн нэр)*

2024.12.16
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА
*(албан тушаал)*

*(гарын үсэг)*

/ А.АМАРСАЙХАН/
*(албан хаагчийн нэр)*

2024.12.19
*(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт*

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8. Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.** | | | | | | | | |
| 1.8.1 | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээний тайлан** | **2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулсан** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцыг жил бүр Засгийн газарт танилцуулсан байна.** | | | |
| 1.8.1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны | Үйл ажиллагаа | Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танил | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын | Төлөвлөгөний хэрэгжилтийг Нийслэл, 21 аймаг, 11 яам, 1 агентлаг, 3 чөлөөт бүсээс | | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг 11 яам, 1 агентлаг, 3 чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас авч нэгтгэн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг гаргаж, нэгтгэх | | цуулга, товч тайлан | ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | хүлээн авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | | дүгнэхэд тухайн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны байдлаар 56.4%-тай байна.<br>Тус төлөвлөгөөний нэгдсэн тайлан, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн төслийг бэлтгэн хэрэгжилтийн тайланг газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар тус газрын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 1/1088 дугаар албан бичгээр тайлан, танилцуулгыг холбогдох мэдээллийн хамт бэлтгэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай 2024 оны 12 сарын 04-нд 1/3364-1/3379 дугаар албан бичгийг холбогдох яамд болон бусад байгууллагуудад тус тус хүргүүлээд байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.17. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | | |
| **1.17.1** | **Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын захиалагчийн техникийн хяналт хийх** | **Захиалагчийн техникийн хяналтын зардал** | **Эцсийн шатны ажлын захиалагчийн техникийн хяналтын дүгнэлт** | **2 удаа дүгнэлт гаргасан.** | | **Эцсийн шатны ажлын захиалагчийн техникийн хяналтын дүгнэлт гаргаж, БХБЯ-нд хүргүүлсэн байна.** | | |
| 1.17.1.1 | Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын захиалагчийн | Захиалагчийн хяналтын зардал | Захиалагчийн хяналт хийсэн дүгнэлт, зөвлөмж, тайлан | Төслийн эцсийн шатны тайлан-1, 2-д хийсэн захиалагчийн хяналтын дүгнэлт гаргаж, Барилга хот байгуулалтын | ХАНСХЕТ-ийн баримт бичгийн төслийг Засгийн газар, УИХ-д танилцуулах, холбогдох тогтоолын төслийг | ХАНСХЕТ-ийн баримт бичгийг орон зайн дэд бүтцийн системд оруулах бүртгэх мэдээллийн өгөгдлийг тодорхойлж, | Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн ажлын тайлангийн хурлыг 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тухайн хурлаар цаашид хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулах, төслийн гэрээний хугацаа болон захиалагчийн хяналтын тайланг нэгтгэх зэрэг асуудлыг хэлэлцсэн.<br>"Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн эцсийн шатны тайланг 2024 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | техникийн хяналт хийх | | | яаманд хүргүүлсэн. | боловсруулах ад хамтран ажилласан байна. | цахим санд оруулах бэлтгэлийг хангасан байна. | оны 03 дугаар сарын 25-ны өдөр гүйцэтгэгч байгууллага Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн бөгөөд төслийн захиалагчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг гаргаж, БХБЯ-нд хүргүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг тус газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/107 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 1 дүгээр хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:<br>1.“Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн явцын товч танилцуулга;<br>2.“Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн танилцуулга.<br>Тухайн хурлаас гарсан шийдвэрийн дагуу тус төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 байгууллага хамтран батлахаар төслийг Барилга, хот байгуулалтын яаманд 2024 оны 05 дугаар сарын 24-нд хүргүүлээд байна.<br>2024 оны 8 дугаар сарын 07-ны ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу эцсийн шатны тайланг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх тухай албан бичгийг Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | |
| 1.17.1.3 | Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, батлуулах | Улсын төсөв | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тоо | 162 хөгжлийн ерөнхий төлөвлөгөө мөрдөгдөж байна. | | Сумын хөгжил: “Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээнд хамрагдах боломжтой сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагуудад санал | Тайлант хугацаанд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Бор-Өндөр уул, Арцатын амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Булган, Хайрхан, Төвшрүүлэх, Өндөр-Улаан сумын Бэлх, Донгой багийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Хэнтий аймгийн Галшар сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаварт санал хүргүүлэн ажилласан.<br>Засгийн газрын хуралдааны 2023 оны 50 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөний баримт бичигтэй болгох ажлыг шуурхай зохион байгуулах тухай тус газрын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 1/1030 дугаар албан бичгийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн бөгөөд | 100 |



5

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн байна. | ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| 1.17.1.4 | “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын хүрээнд ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажилд оролцох | Үйл ажил лагаа ны зардал | Хамтран зохион байгуулсан арга хэмжээ | - БХБЯ-ны захиалгаар “Орхоны хөндийд шинэ хот байгуулах газар сонгох, хот байгуулах ТЭЗҮ” боловсрогдсон. - ”Шинэ хар хорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулагдсан. | | -”Шинэ Хар хорум” хотын хөгжлийн концепцийг боловсруулахад хамтран оролцсон байна. -Шинээр байгуулах хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаварт санал өгсөн байна. | ”Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа дээр боловсруулагдаж байгаа бөгөөд тухай бүрт ажлын хэсэгт мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.<br>“Шинэ Хархорум” хотын төлөвлөлтийн үзэл баримтлалыг боловсруулах олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын дүн 2024 оны 8 дугаар сарын 2-ны өдөр гарсан ба 1 дүгээр байранд “Хятадын зам, гүүрийн корпорац, хятадын төрийн барилгын инженерийн корпорац, хятадын харилцаа холбоо, барилгын компанийн салбар хурдны замын зөвлөх үйлчилгээний компанийн хамтарсан баг болон Зүүн Хятадын Архитектурын зураг төсөл, судалгааны хүрээлэн ХХК-ийн баг шалгарлаа. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.18. Шинэ Зуунмод, Майдар шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ.** | | | | | | | | |
| **1.18.1** | **Хөшигийн хөндийг даган хөгжих “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар боловсруулах, захиалагчийн техникийн хяналт хийх** | **Захиалагчийн техник-ийн хянал-тын зардал** | **3 ажлын даалга вар, Захиа лагчийн техник ийн хянал тын дүгнэлт** | - | **Ажлын даалгавар боловс руулж батлуулсан байна. Захиалагчийн техникийн хяналтын дүгнэлтийг БХБЯ-нд хүргүүлсэн байна.** | | | |
| 1.18.1.1 | Шинэ Зуунмод болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих төсөлтэй | Үйл ажил-лагаа | Хамтран зохион байгуулсан арга хэмжээ | - | Шинэ Зуунмод болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийг | | Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны А/29 дугаар тушаалаар нийт 20 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулсан. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллах, төсөлд санал өгөх | | | | дэмжих төсөлтэй хамтран ажиллах, төсөлд санал өгсөн байна. | | Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулсан бөгөөд “Шинэ Зуунмод болон эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих төсөл”-ийн төлөвлөгөө боловсруулагдан батлагдаж, тухайн төлөвлөгөөний дагуу үе шатны ажлууд хийгдэж байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.19. Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг "Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн 20 жилээр төлөвлөнө.** | | | | | | | | |
| **1.19.1** | **Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг холбогдох байгууллагууд-тай хамтран боловсруулах** | **Захиалаг чийн техникийн хяналтын зардал** | **Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө** | **2030 он хүртэлх чиг хандлага хэрэгжиж байгаа.** | | **Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөл-тийн цахим систем”-д бүртгэх ажлыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.19.1.1 | Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулах | Үйл ажиллагаа | Мэдээ, мэдээлэл | Ажлын хэсэг байгуулагдсан. Төсөл боловсруулагдсан. | | Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Засгийн газарт танилцуулах, УИХ-д өргөн барихад шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, БХБЯ-тай хамтран ажилласан байна. | Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Засгийн газарт танилцуулах, УИХ-д өргөн барихад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах ажлыг Барилга, хот байгуулалтын яамтай хамтран хийж гүйцэтгэж байна.<br>“Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж, ажлын даалгавар батлагдсан бөгөөд тухайн ажлын ажил гүйцэтгэх гэрээг нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Дэхан консалтентс” ХХК -тай байгуулсан болно. | - |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.22.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажил-лагаа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
| 1.22.2.9 | “Хот суурин газрын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн ашиглалтын хязгаарлалтыг тогтоох нийтлэг дүрэм”-ийн төслийг боловсруулах | Үйл ажил лагаа | Дүрмийн төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл | - | | “Хот суурин газрын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн ашиглалтын хязгаарлалтыг тогтоох нийтлэг дүрэм”-ийн төсөлд холбогдох байгууллагад санал хүргүүлсэн байна. | “Хот суурин газрын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн ашиглалтын хязгаарлалтыг тогтоох нийтлэг дүрэм”-ийн төслийг эхний байдлаар боловсруулсан. | 50 |
| 1.22.2.33 | Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээлэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | Үйл ажил лагаа | Сургалтын тоо<br><br>Хамрагдсан иргэн, хуулийн этгээд-ийн тоо | 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | Газрын харилцааны салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | | Газрын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, цахим системээр дамжуулан газар ашиглалтын зохистой менежментийг хэрэгжүүлэх, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулах талаарх холбогдох журам, зааврыг танилцуулж, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 30-наас 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд Увс аймгийн Улаангом хотод зохион байгуулж, сургалтад Завхан, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүд, газрын даамлууд нийт 40 орчим албан хаагчид хамрагдсан.<br>- “Нийслэл, 21 аймгийн хэмжээнд хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний гэрээт ажлыг хүлээлгэн өгөхтэй холбогдуулан цахим системийг ашиглах мэргэжилтэн, албан хаагчдыг чадавхжуулах сургалтын бэлтгэл ажлыг хангаж, 21 аймгийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ГХБХБГ-ын ерөнхий архитектор, хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн, инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн, нийт 54 албан хаагчдыг хамруулсан сургалтыг Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургууль дээр 2024 оны 02 дугаар сарын 19-нөөс 22-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>- Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/77 дугаар тушаалаар батлагдсан "Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг хэлтсүүдэд танилцуулан орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулах талаарх чиглэлийг өгсөн.<br>- Газар харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд хийж гүйцэтгэх 70 бүтээлч ажлын төлөвлөгөөг газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалаар батлуулан орон нутагт хүргүүлэн, мөн байгууллагын Able системд байршуулан хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг өгсөн.<br>- Барилга, хот байгуулалтын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, ШУТИС-ийн Барилга архитектурын сургууль, КОЙКА олон улсын байгууллага болон Сөүлийн Үндэсний их сургуулийн хамтарсан "Монгол улсын хот байгуулалтын дээд боловсролын чадавхийг бэхжүүлэх" S-QUAD төслийн хүрээнд Монгол Улсын хот байгуулалтын салбарын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор богино хэмжээний сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, 21 аймгийн ерөнхий архитекторуудад "Хотын эрх зүй" сэдвээр БНСУ-ын Архитектор, хотын товчооны ерөнхийлөгч Hyek Kyung Youn, "Хот төлөвлөлт ба зураг төслийн программ хангамж" сэдвээр БНСУ-ын Архитектор, Солонгосын хот төлөвлөлтийн хүрээлэнгийн гишүүн Woo Jin Lee нар илтгэл тавьж санал солилцсон.<br>- Газар зохион байгуулалтын төлөвлөлт болон Хот төлөвлөлтийн цахим системийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулсан.<br>- 2024 оны 06 дугаар сарын 13-ний өдрүүдэд нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба болон 21 аймгийн ГХБХБГ-ын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан "Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх" сэдэвт сургалтын хүрээнд хээрийн судалгааны дадлага ажлыг удирдан зохион байгуулсан. | |
| 1.22.4.35 | Газар зохион байгуулалт, суурь судалгаа, мониторинг, газрын кадастрын, хот байгуулалтын чиглэлээр боловсруулагдаж буй журам, заавар, аргачлалд санал өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах | Үйл ажил лагаа | Санал өгсөн баримт бичгийн тоогоор | - | Хэлтсүүдийн шинээр боловсруул сан, болон шинэчлэн найруулсан журам, заавар, аргачлалд санал өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | Хэлтсүүдийн шинээр боловсруулсан, болон шинэчлэн найруулсан журам, заавар, аргачлалд санал өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан байна. | - Газар зохион байгуулалт хийх журмын төсөл, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын төсөлд санал хүргүүлсэн.<br>- Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас боловсруулан санал авахаар ирүүлсэн "Газрын эрхийн маргаан таслах зөвлөлийн ажиллах журам", "Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам"-тай танилцан санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн.<br>- Газрын даргын 2023 оны А/194 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан "Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-ын төсөл, газрын даргын 2023 оны А/198 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам", байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам", "Газрын доройтлыг тодорхойлох, доройтсон газрыг нөхөн сэргээх журам"-ын, Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлал, Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний аргачлалын төсөлд тус тус санал өгсөн.<br>- Хяналт, үнэлгээний үндэсний хорооноос ирүүлсэн Мониторинг хийх нийтлэг журмын төсөлтэй танилцаж, санал боловсруулан хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - "Хотын стандарт орчны аюулгүй байдлын газар"-аас боловсруулсан дараах стандартын төслүүдэд санал өгч холбогдох газарт хүргүүлсэн. Үүнд:<br>• Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага;<br>• Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага;<br>• Нийтийн тээврээр зорчих гудамжны төлөвлөлт хийх удирдамж;<br>• Авто машинаар зорчих гудамжны төлөвлөлт хийх удирдамж;<br>• Ногоон байгууламж бүхий гудамж төлөвлөх түүнд хэрэглэгдэх мод, бут, сөөг сонгох ерөнхий шаардлага;<br>• Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл.<br>"Геодези, зураг зүй, газар зохион байгуулалт, орон зайн мэдээллийн технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2024 оны А/77, "Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2024 оны А/120 дугаар тушаалаар тус тус батлуулсан. | |
| **1.22.3** | **Газрын харилцааны салбарын бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтийг хангах** | **Үйл ажил-лагаа** | **Бодлого, стратег -ийн баримт бичгүүд** | - | **Газрын харилцааны салбарт мөрдөх бодлого, стратегийн баримт бичгийг боловсруулж, батлуулсан байна.** | | | |
| 1.22.3.1 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр | Үйл ажиллагаа | 1 хөтөлбөр | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан 2020-2024 оны | Үйл ажиллагааны хөтөлбөрт оруулах саналыг боловсруулах, Засгийн | Саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дүгнэлтийг гаргахад шаардлагатай 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд оролцох улс төрийн нам, эвслээс мөрийн хөтөлбөрт газрын харилцааны чиглэлээр тусгах асуудлын саналыг хэлтсүүдээс авч нэгтгэсэн саналыг | 100 |



54

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | оруулах саналыг боловсруулах | | | үйл ажиллагааны хөтөлбөр | газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | | хянан, холбогдох газарт, мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.2.а, 6.8.2.б заалтад заасан шаардлагад нийцүүлэн гаргаж, 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 1/2878 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. | |
| 1.22.3.2 | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах | Үйл ажиллагаа | жилийн төлөвлөгөөний төсөл | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний саналыг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төслийг Санхүү, эдийн засгийн хэлтэстэй хамтран боловсруулж, салбарын өнөөгийн байдал, тоон үзүүлэлтүүдийг 2018-2023 оны байдлаар, мөн салбарын 2024-2025 болон 2025-2027 оны хөгжлийн төсөөлөл, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, салбарт тулгарч болзошгүй эрсдэлийн талаарх танилцуулгыг бэлтгэн төлөвлөгөөний төсөлд хавсаргасан.<br>Тухайн төлөвлөгөөний төслийг тус газрын 2024 оны 1/124 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 100 |
| 1.22.3.3 | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулж, батлуулах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2021-2024)-г 2021 онд БХБС-аар батлуулсан. | | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулж, батлуулсан байна. | Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын стратеги төлөвлөгөө" (2025-2028) боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээг хийх хуваарийг гарган газрын даргаар батлуулав.<br>Тухайн стратегийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг Газрын даргын 2024 оны А/264 дүгээр тушаалаар байгуулж, уг тушаалын | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хавсралтаар төлөвлөгөө боловсруулах хуваарийг батлуулав.<br>Уг ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж, холбогдох хууль тогтоомжоос тухайн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах чиг үүргийг тодорхойлон, тухайн чиг үүргүүдийг үйл ажиллагааны чиглэлээр ангилан салбар хоорондын болон засаглалын түвшин хоорондын холбогдогч талуудын оролцоог тодорхойлох, гадаад, дотоод орчны шинжилгээ хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүдэд зориулан Удирдлагын академитай хамтран “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулав.<br>Стратегийн зорилго, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн уялдааг гаргах, стратегийн зорилго, зорилтыг тодорхойлох ажлууд газрын даргын тушаалын хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу хийгдэж байна. | |
| 1.22.4 | **Салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, хууль тогтоомж, гүйцэтгэлийн төлөвлөгөө, зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, зөвлөмж гаргах** | **Үйл ажиллагаа** | **Бодлого, стратегийн баримт бичгүүдийн хэрэг жилт** | - | | **2021-2024 онд хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт хангагдсан байна.** | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.4.1 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хэрэгжилтийг гаргаж тайлагнах | Үйл ажиллагаа | Үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. | | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 16 арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.unelgee.gov.mn)-д тухайн арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнасан. | 100 |
| 1.22.4.2 | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнах | Үйл ажил-лагаа | Төлөвлөгөөний биелэлт | Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлагдсан. | | Төлөвлөгөөний биелэлтийг гаргаж тайлагнасан байна. | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх, мөн газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох хэлтсүүдээс авч тайлагнасан. | 100 |
| 1.22.4.3 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг гаргаж тайлагнах | Үйл ажиллагаа | Газрын харилцаа-тай холбоотой бүх тогтоол, шийдвэр | - | Тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг гаргаж, тайлагнасан байна. | Тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг гаргаж, тайлагнасан байна. | - Засгийн газрын 2023 оны "2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай" 481 дүгээр тогтоолд заасны дагуу Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийн хэлэлцүүлгийг хөгжлийн бүс тус бүрээр болон нэгдсэн байдлаар зохион байгуулсан тухай хэрэгжилт;<br>- Засгийн газрын 2024 оны 01 дугаартай албан даалгаврын 4.1 дэх заалт, буюу 2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг шинэчлэн боловсруулах, "Хөгжлийн бүсийн зөвлөгөөн (форум)"-ийг бүсүүдэд болон нэгдсэн байдлаар зохион байгуулах, 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх 100 хоногийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж нэгтгэн, Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.4.4 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг гаргаж, биелэлтийг тайлагнах | Үйл ажиллагаа | Хөгжлийн бодлого төлөвлөлт | Урт, дунд хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичиг | Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн биелэлтийг холбогдох нэгжүүдээс хүлээн авч нэгтгэн тайлагнасан байна. | Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн биелэлтийг холбогдох нэгжүүдээс хүлээн авч нэгтгэн тайлагнасан байна. | Монгол Улсын Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.unelgee.gov.mn)-д Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5 арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу нэгтгэн гаргаж тайланг баталгаажуулсан.<br>Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2524 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан /unelgee.gov.mn/-д тайланг байршуулан баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. | 100 |
| 1.22.4.5 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж байгаа ажлуудад хяналт тавих | Үйл ажиллагаа | батлагдсан төсвийн хүрээнд | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал төсвөөр хийгдэж буй ажлуудын явцад хяналт тавьж хэрэгжилтийг хангаж ажилласан байна | Гэрээт ажлуудын эцсийн гүйцэтгэлийг хүлээн авах ажилд тавьж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | - Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрын нөхөн сэргээлтийн аргачилсан заавар боловсруулах, газрын мониторингийн 300 цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх, газрын мониторингийн цэгийг шинээр байгуулах шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аргачилсан зааврыг боловсруулах ажлын даалгаварт санал өгч, батлагдсан ажлын даалгаврын дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.<br>- "Некст степ инженеринг" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн "Чингис хаан олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг даган бий болох шинэ хот (Аэросити)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах гэрээт ажлын баримт бичиг хүлээн авсан акт, гэрээний хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээний төслийг 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/649 дүгээр албан бичгээр | 100 |



58

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.<br>- Монгол Улсын Сангийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх дараах төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн Санхүү, эдийн засгийн хэлтсийн холбогдох мэргэжилтэнтэй хамтран Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Газрын биржийн цахим системийн хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн шинэчлэл;<br>- "Улсын хэмжээнд гурав болон дөрвөн /3D, 4D/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх";<br>- "Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх". | |
| 1.22.4.6 | **Газар зохион байгуулалт, хот байгуулалт, газрын мониторинг, газрын кадастрын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх** | Үйл ажил-лагаа | Мэдээ, мэдээлэл | - | Газар зохион байгуулалт, хот байгуулалтын чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил хийж холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | Газрын монторинг, газрын кадастрын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | Тус газрын Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу хот байгуулалт, ногоон байгууламж, төрийн захиргааны барилга байгууламжийн судалгаа хийн ахлах мэргэжилтнээр хянуулж, газрын даргад дэлгэрэнгүйгээр танилцуулсан. Хийсэн судалгаан дээр үндэслэж хураангуй танилцуулгын самбар бэлдсэн.<br>Улаанбаатар хотын барилгажилтын 3 хэмжээст мэдээллийг Google Earth платформд нэвтрүүлж, олон нийтэд түгээх талаар суурь судалгааг хийн газрын даргад танилцуулсан.<br>Төр захиргааны байгууламжийн төлөвлөлт хийх газрын нэршлийн түүхэн судалгааг Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаатай холбогдон хийж гүйцэтгэсэн.<br>Удирдлагаас үүрэг өгөгдсөний дагуу газрын харилцааны цахим үйлчилгээний КИОСК машины талаарх судалгааг хийж, удирдлагад танилцуулсан бөгөөд тухайн судалгааг байгууллагын цахим хуудсанд оруулсан. | 100 |



59

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.22.6** | **“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх** | **Үйл ажил-лагаа** | **Санал өгсөн байдал** | **Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан.** | | **“Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах ад санал өгсөн байна.** | | |
| 1.22.6.1 | “Бүсчилсэн хөгжлийг дэмжих – Хариуцлагатай газрын харилцаа”-ны жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэг жүүлсэн арга хэмжээний тоо | ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласан. | | Нэрэмжит жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан холбогдох нэгжүүдтэй хамтран хэрэгжилтийг хамтран зохион байгуулсан байна. | - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 428 дугаар тогтоолоор Үндэсний орон сууцжуулалтын үндэсний хороог байгуулсантай холбогдуулан орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр газрын харилцааны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 01 дүгээр сард ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоолоор 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил”, мөн тус газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/05 дугаар тушаалаар 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа”-ны жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх газрын даргын 2024 оны 01 тоот албан даалгаврыг боловсруулан газрын даргаар батлуулсан. Албан даалгаврыг тус газрын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/459 тоот албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн.<br>- Газрын даргын 2024 оны А/04 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын сарын 27-ны өдрийн 482 дугаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоолоор Үндэсний орон сууцжуулалтын Үндэсний хороог байгуулсантай холбогдуулан орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, газрын харилцааны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санал өгч батлуулсан.<br>Улаанбаатар – Бүсчилсэн хөгжил форумд 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр, Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд сэдэвт салбар дундын хуралд 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр газрын мэргэжилтнүүд тус тус оролцсон.<br>"Бүсчилсэн хөгжлийг дэмжих-Хариуцлагатай газрын харилцаа"-ны жилийн хүрээнд гаргасан газрын даргын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг гаргах зорилгоор нийслэлийн ГЗБА болон 21 аймгийн ГХБХБГ-т тус газрын 2024 оны 11 дүгээр сарын 19-ний "Албан даалгаврын хэрэгжилт, тайлан ирүүлэх тухай" 1/3177 дугаар албан бичгийг хүргүүлэв. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **3.1.11** | **Хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | - | | **Хот байгуулалтын чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.** | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.11.1 | Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зургийн даалгаврыг зөвшилцөх | Үйл ажиллагаа | Зөвшилцөн санал гаргасан даалгаврын тоо | хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, салбарын төсөл хөтөлбөр хүрээнд төлөвлөгдсөн ажлын зургийн даалгавар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 39 зургийн даалгаврын төслийг хянаж, санал өгсөн. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд зургийн даалгавар боловсруулах санал авах модуль хөгжүүлсэн. | | Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, салбарын төсөл хөтөлбөр хүрээнд төлөвлөгдсөн ажлын зургийн даалгавар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний даалгаврын төсөлд холбогдох байгууллагад санал хүргүүлсэн байна. | Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, салбарын төсөл хөтөлбөр хүрээнд төлөвлөгдсөн ажлын зургийн даалгавар, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний даалгаврын төсөлд холбогдох байгууллагад санал хүргүүлэх ажлын хүрээнд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Бор-Өндөр уул, Арцатын амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Булган, Хайрхан, Төвшрүүлэх, Өндөр-Улаан сумын Бэлхи, Донгой багийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Хэнтий аймгийн Галшар сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаварт санал хүргүүлэн ажилласан.<br><br>Орхон аймгийн Баян-Өндөр, Ховд аймгийн Булган, Буянт, Дарви, Дуут, Мөнххайрхан, Мөст, Мянгад, Үенч, Ховд, Чандмань, Эрдэнэбүрэн, Архангай аймгийн Булган, Хайрхан, Төвшрүүлэх, Баянхонгор аймгийн Жаргалант, Хүрээмарал, Сэлэнгэ аймгийн Мандал, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар багийн Амины орон сууцны хороолол, 13 дугаар багийн Аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний цогцолбор хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зургийн даалгаварт санал хүргүүлэн ажилласан. | 100 |
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулагдсан арга хэмжээ** | **2023 онд 14 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна** | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.8.3 | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдаан зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврыг албажуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хуралдааны тоо<br>- Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл | 2023 онд Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл 6 удаа хуралдсан. | | Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийг албажуулж, тайлагнасан байна. | "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, орон зайн мэдээлэл технологийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулж, газрын даргын 2024 оны А/77 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах зарыг байгууллагын цахим системд анкетын хамт байршуулан зөвлөлийн гишүүдийг сонгох ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/176 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.<br>Тус зөвлөлийн шинэчилсэн бүрэлдэхүүний анхдугаар хурлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, мэргэжлийн зөвлөлийн дарга болон орлогч даргыг сонгон 2024 онд тухайн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг хэлэлцүүлэв. Тус хурлаас гарсан шийдвэрийн дагуу зөвлөлийн дарга, орлогч даргыг газрын даргын 2024 оны А/197 дугаар батлуулав. Мөн тухайн зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд шаардлагатай зардлын тооцоог гарган дээрх тушаалын хавсралтаар батлуулсан. Тус орон тооны бус зөвлөлийн хурлаар 2024 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна.<br>Байгууллагын стратеги, бүтцийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу тус газрын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг газрын даргын 2024 оны А/177 дугаар тушаалаар батлууллаа.<br>Тухайн зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 21-ний | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрийн хурлаар хэлэлцүүлэн газрын даргын 2024 оны А/120 дугаар тушаалаар батлуулав. Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж 6 асуудал, 08 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, 3 асуудал, 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, 3 асуудал тус тус хэлэлцүүлэв. Тухайн хурлуудын тэмдэглэлийг бичиж, шийдвэрийг Зөвлөлийн даргаар албажуулан холбогдох хэлтэст хүргүүлэв.<br>Байгууллагын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлыг 2024 оны 11 дүгээр 18-ний өдөр хуралдуулж, "Газар зүйн нэрийг тодотгох, тогтоох, солбицолжуулах, баталгаажуулах, газар зүйн нэрийн зураг зохиох дүрэм"-ийн төслийг хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулан холбогдох хэлтэст өгөв. | |
| 4.1.8.5 | Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөгөө, арга хэмжээний тоо | "Газрын харилцааны ажилтны өдөр"-ийг 2023 оны 4, 5 дугаар сард зохион байгуулсан. | | Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ой, Газрын харилцааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж, арга хэмжээг зохион байгуулсан байна. | - Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд хийж гүйцэтгэх 70 бүтээлч ажлын саналыг агентлагийн газар, хэлтсүүд, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн ГХБХБГ-аас санал авч нэгтгэн боловсруулж, газрын даргын дэргэдэх Зөвлөлийн хуралд танилцуулан Газрын даргын 2024 оны А/70 дугаар тушаалаар батлуулан, тус газрын 2024 оны А/364 тоот албан бичгээр нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн ГХБХБГ-т хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг өгсөн.<br>- Монгол Улсад газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ой, Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан "Ж.Наранцацралт багшийн нэрэмжит газрын харилцааны салбарын оюутны эрдэм шинжилгээний хурал - 2024" эрдэм шинжилгээний | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хурлыг Монгол Улсын Их сургуулийн Газарзүйн тэнхим, Наранцацралт сантай хамтран зохион байгууллаа.<br>- Монгол Улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойд зориулан салбарын жуух бичиг болон энгэрийн тэмдгийн судалгааг хийж гүйцэтгэсэн.<br>- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоотой хамтран Баянзүрх дүүргийн "Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн"-нд Геодези, зураг зүйчдийн нэрэмжит төгөл байгуулах үйл ажиллагаанд оролцсон бөгөөд тус ажлын зарлалын самбар болон хөтөлбөрийн загварыг гаргасан.<br>- "Хариуцлагатай газрын харилцаа" аян, Монгол Улсын Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд Газрын даргын 2024 оны А/148 дугаар тушаалаар газрын харилцааны хууль, дүрэм журам, салбарын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах, иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн эрх, үүрэг, газрын зөрчил маргаан, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх сургалтын үйл ажиллагаанд ашиглах товхимлыг хэвлүүлэх, худалдан авах гэрээ хийх ажлыг зохион байгуулсан.<br>- Тухайн ажлын хүрээнд байгууллагаас зохион байгуулсны дагуу "Улаанбаатар марафон"-д газрын мэргэжилтнүүд оролцсон.<br>- Тус газрын ахлах мэргэжилтнүүд 70 жилийн ойн хүрээнд ном, товхимол бэлтгэн гаргах ажлын хэсэгт ажиллаж мэдээллүүдийг бэлтгэж, ажлын хэсэгт өгсөн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - 70 жилийн ойн баярын зочдод гардуулах гарын бэлгийн төслийг хийж, гэрээт байгууллага руу хүргүүлсэн.<br>- Баярын хурал болон хүлээн авалтын урилгын загварыг гарган байгууллагын удирдлагад танилцуулсан.<br>- Ойн үзэсгэлэнгийн төлөвлөгөөг боловсруулах зорилгоор Төрийн ордны Их танхим, холбогдох орон зайн план зургийг гаргасан. | |
| 4.1.8.7 | Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх санал боловсруулах | Үйл ажиллагаа | Олон улсын туршлага | - | Газрын харилцааны чиглэлээр олон улсын туршлага, техник технологийн ололтыг судалж, хэрэглээнд нэвтрүүлэх санал боловсруулж, нэвтрүүлсэн байна. | | - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүжин тээвэр, нүхэн гарц болон аялал жуулчлалын цогцолборын судалгааг олон улсын туршлага дээр үндэслэн газрын даргад танилцуулсан. Хийсэн судалгаа дээр үндэслэж хураангуй танилцуулгын самбар бэлдсэн.<br>- Байгууллагын цахим системүүд болон цахим хуудасны загвар, ашиглалт, гадаад хүртээмжийн талаар дүн шинжилгээг хийж, олон улсын туршлага дээр үндэслэн сайжруулах санал боловсруулж газрын даргад танилцуулсан.<br>- Шинэчилсэн цахим хуудасны байгууллагын талаарх үндсэн мэдээллүүдийг англи хэл рүү орчуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. | 100 |
| 4.1.8.8 | Газрын харилцааны чиглэлээр олон улсын болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал боловсруулах | Үйл ажиллагаа | Хамтран ажиллах санал | - | Олон улсын болон гадаад дотоодын байгууллагууд-тай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | Олон улсын болон гадаад дотоодын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал боловсруулж холбогдох хурлаар хэлэлцүүлсэн байна. | 2024 онд зохион байгуулагдах олон улсын газрын харилцаа, хот байгуулалт, төлөвлөлтийн чиглэлээр болох төсөл, хөтөлбөр, уулзалт, форум арга хэмжээний судалгааг нэгтгэн гаргасан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар хот байгуулалтын чиглэлээр 8 орны 12 арга хэмжээний танилцуулгыг бэлдсэн байна.<br>Суурь судалгаан дээр үндэслэн тогтвортой хотжилтын асуудлын талаарх дэлхийн тэргүүн бага хурал болох Дэлхийн хотын форумын тухай дэлгэрэнгүй судалгаа болон танилцуулгын материал бэлдсэн.<br>Австрали Улсын Сидней хотод болсон НҮБ-ын Ази, Номхон далайн дэлхийн гео-орон зайн мэдээллийн менежментийн хорооны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Гүйцэтгэх зөвлөлийн хуралд байгууллагын удирдах ажилтнуудыг бүртгүүлэх болон Австрали улсын виз мэдүүлэх ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>БНСУ-ын Төрийн захиргаа, аюулгүй байдлын яамтай хамтран байгуулсан хаягийн нэгдсэн мэдээллийн системийг шинэчлэх тухай санамж бичгийн англи, монгол хувилбарыг тулган хянаж, утга агуулга, дүрмийн нэмэлт засвар хийн эцсийн хувилбарыг боловсруулах ажилд оролцож ажилласан.. 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр уг санамж бичгийг БНСУ-ын Сөүл хотод баталсан. Тухайн ажилтай холбогдуулан 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр төслийн ТЭЗҮ-ийг танилцуулах хурлын ложистикийн бэлтгэл ажлыг хангах ажлыг зохион байгууллаа. Улаанбаатар хотын Сөүлийн гудамжинд зохион байгуулагдсан хаягийн системийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсон.<br>JICA руу явуулсан "Монгол улсын үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц, байнгын ажиллагаатай станцуудыг (CORS) сайжруулах төсөл"-ийн монгол орчуулгыг хийж, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн газрын даргад хүлээлгэж өгсөн. БНХАУ-н ZҮЗ хийммэл дагуулаас мэдээлэл хүлээн авах, боловсруулах, нийтлэх ажлыг үргэлжлүүлэх зорилгоор албан шуудан хүргүүлж, санамж бичгийн хугацааг сунгахаар ажиллаж байна. | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 4.1.1 | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг | Үйл ажиллагаа | Үүрэг даалгаврын тоо | Жил бүр хийгддэг. | | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, | Тус газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, газрын 7 хоног тутмын шуурхай зөвлөгөөн, газар, нэгжийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | | | | | тухай бүр тайлагнасан байна. | тухай бүр хэрэгжүүлэн, биелэлтийн тайланг байгууллагын Абле системд оруулан, хэрэгжилтийг хангаан ажиллаж байна. | |
| 4.1.2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тушаалд заасан хугацаа | Жил бүр хийгддэг. | | Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | Газрын даргын тушаалаар байгуулагдсан дараах ажлын хэсгүүдэд ажиллаж, ажлын тайланг тухай бүр тайлагнан ажиллаж байна. Үүнд:<br>- Газрын даргын 2023 оны А/190 дүгээр тушаалаар байгуулагдсан Өмнөговь аймгийн Ханбогд суманд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газарт өгсөн чиглэлийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд газар эзэмшүүлж, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулах ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2023 оны А/194 дүгээр тушаалаар байгуулагдсан "Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн ажиллах журам" боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2023 оны А/198 дугаар тушаалаар байгуулагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны 01 сарын 02-ны А/01 дүгээр тушаалаар байгуулагдсан Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас баталсан маягт, загварын дагуу хүлээн авч, нэгтгэн боловсруулж, дүгнэлт гарах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар байгуулагдсан "Орон сууцны хүртээмжийг "5М" зэргээр төрөлжүүлэн нэмэгдүүлэхэд газрын харилцааны чиглэлээр дэмжлэг үзүүлэх, авч хэрэгжүүлэх | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/07 дугаар тушаалаар байгуулагдсан тус газрын болон орон нутгийн мэргэжилтнүүдийн шинээр бий болсон болон шинэчлэгдсэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/17 дугаар тушаалаар байгуулагдсан иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, эзэмшүүлсэн, ашиглуулсан асуудлыг шалгаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийн дагуу Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт ажиллах ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/87 дугаар тушаалаар байгуулагдсан Евроазийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/107 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан “Монгол Улсын Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн захиалагчийн техник хяналт хийх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Барилгын салбарын удирдах ажилтны форум-2024” арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/176 дугаар тушаалаар батлагдсан Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл;<br>- Газрын даргын 2024 оны А/177 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн зөвлөл;</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Газрын даргын 2024 оны А/235 дугаар тушаалаар баталагдсан Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн цаасан болон цахим ном хийх дэд ажлын хэсэг;<br>- Газрын даргын 2024 оны А/264 дүгээр тушаалаар байгуулагдсан "Байгууллагын стратеги төлөвлөгөө (2025-2028) боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг; | |
| 4.1.3 | Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | Жил бүр хийгддэг. | | Холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд тайлагнасан байна. | - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 5 арга хэмжээ, 24 дүгээр тогтоолын 16 арга хэмжээний биелэлтийг гаргаж хугацаанд нь тайлагнасан.<br>- Засгийн газрын 2023 оны "2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай" 481 дүгээр тогтоолд заасны дагуу Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийн хэлэлцүүлгийг хөгжлийн бүс тус бүрээр болон нэгдсэн байдлаар зохион байгуулсан тухай хэрэгжилт;<br>- Засгийн газрын 2024 оны 01 дугаартай албан даалгаврын 4.1 дэх заалт, буюу 2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг шинэчлэн боловсруулах, "Хөгжлийн бүсийн зөвлөгөөн (форум)"-ийг бүсүүдэд болон нэгдсэн байдлаар зохион байгуулах, 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх 100 хоногийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж нэгтгэн, Хуулийн хэлтэст хүргүүлсэн. | 100 |
| 4.1.4 | Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | Үйл ажиллагаа | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо | Жил бүр хийгддэг. | | Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | - Тайлант хугацаанд тухайн газарт нийт 110 албан бичиг ирснээс хариутай 29 хариугүй 79 байна. Хариутай бичгүүдийг хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд хугацаа хоцорсон шийдвэрлэлт байхгүй байна. Мөн 1 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн байна.<br>- Тус газраас 2024 онд нийтдээ 106 албан бичгийг боловсруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Тайлант хугацаанд Эдийн засгийн хөгжлийн яамнаас ирүүлсэн "Монголын эдийн засгийн чуулган-Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн"-д оролцох албан тушаалтнуудын мэдээллийг ирүүлэх тухай албан бичгийн хариуг тус газрын 2024 оны 1/205 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Мөн Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл"-ийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийн хариуг тус газрын 2024 оны 3/289 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Газрын даргын 2024 оны 1/1092 дугаартай албан бичгээр улсын байцаагчийн 2023 оны 02-13-04/018/03 дугаар дүгнэлтэд хамаарах 114 хуудас нотлох баримтыг хүргүүлсэн.<br>- "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайланг Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2524 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>- Бүгд Найрамдах Холбооны Герман Улсын Ахмад мэргэжилтний албанаас ирүүлсэн Европын холбооны зарчимтай уялдуулан Монгол Уллсын газрын үнэлгээ, төлбөр, татварын системийг шинжих, дүгнэх тухай Томас Шенк мэргэжилтний ажлын гэрээний хариуг хүргүүлсэн.<br>- Бүгд Найрамдах Азербайжан Улсын Азеркосмос агентлагаас Евразийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хуралд оролцох тухай албан бичгийг хүлээн авсан.<br>- Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас ирсэн Япон Улсын Гео-орон зайн мэдээллийн албатай байгуулсан хамтын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааны санамж бичгийг бүртгэн авах тухай 09/3957 дугаар албан бичгийг хүлээн авсан. Хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хүргүүлэхээр төлөвлөөд байгаа.<br>- Сити их сургуулийн Хамтран ажиллах хүсэлт хүргүүлэх тухай 2024 оны 03/90 дугаар албан бичигт хариу илгээсэн.<br>- Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилтийн тайланг ирүүлэх тухай 2024 оны 12 сарын 04 нд 1/3364- 1/3379 дугаар албан бичгийг яамдууд болон холбогдох байгууллагуудад тус тус хүргүүлсэн.<br>- Дундговь аймгийн ГХБХБГ-т 2024 оны 11 сарын 13-ны 1/3092 дугаар албан бичгээр 2025 онд орон нутгийн төсөвт тусгуулж, гүйцэтгэх ажлын талаар чиглэл хүргүүлсэн. | |
| 4.1.5 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Үйл ажиллагаа | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | Жил бүр хийгддэг. | | Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | - Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тухайн онд ирсэн нийт 20 бичгүүдийг хүлээн авч шийдвэрлэн архивт хүлээлгэн өгсөн.<br>- Өмнөговь аймгийн Ханбогд сумын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын ажлын нэгдсэн тайланг байгууллагын архивт зохих шаардлагыг хангаж хүлээлгэн өгсөн.<br>- Газар геодези, зураг зүйн хяналтын Улсын ахлах байцаагчийн баталсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтын 02-13-04/09, 02-13-04/11, 02-13-04/13, 02-13-04/21, 02-13-04/24, 02-13-04/35, 02-13-04/43 дугаар бүхий удирдамжийн хүрээнд хийгдсэн 6 танилцуулгыг бичиж "Хяналт шалгалтын танилцуулгыг удирдах албан тушаалтанд танилцуулах хуудас"-аар танилцуулж, архивлан хадгаламжийн нэгж үүсгэсэн. | 100 |

## ТАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | |